

## ЖИНСТ УВС ХК

### ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2017 оны 4-р сарын 21-ний өдөр

№17/.../

Улаанбаатар хот

Хурлын огноо: 2016 оны 04 сарын 21-ний өдөр

Хурлын цаг: 15:00 цагаас 16:20

Хурлын байршил: Сүхбаатар дүүрэг, Ерөнхий Сайд Амарын гудамж-2, Ард Холдингсын байр, 2 давхрын хурлын танхим.

Хурлын дарга: С.Халиунаа

Хурлын нарийн бичгийн дарга: Ж.Алтангүний

Хуралд оролцсон Төлөөлөн удирдах зөвлөлийн /цаашид "ТУЗ" гэх/ гишүүд:

1. Ө.Ашхүү;
2. А.Батболд;
3. Ч.Ганзориг;
4. Б.Ганбат;
5. Х.Далайбаяр;
6. Д.Мөнхтөр;

Хуралд урилгаар оролцож буй хүмүүс:

- |               |                            |
|---------------|----------------------------|
| 1. Б.Оюунсүвд | Ерөнхий нягтлан бодогч     |
| 2. Н.Мөнхбат  | Тооллогын комиссын дарга;  |
| 3. Г.Билгүүн  | Тооллогын комиссын гишүүн; |

Хурлын ирц: 84.79% буюу бүрэн.

Оролцсон хувьцаа эзэмшигчид:

|   | Нэр                                              | Хувьцааны тоо | Хувь  |
|---|--------------------------------------------------|---------------|-------|
| 1 | Ард Санхүүгийн Нэгдэл ХК-г төлөөлж Ж.Дамбаасүрэн | 45,028        | 84.60 |
| 2 | Д.Мөнхтөр                                        | 101           | 0.19  |
|   | Нийт                                             | 45,129        | 84.79 |

Хурлын дарга, С.Халиунаа хурлын дэг, хурлаар хэлэлцэх асуудлыг танилцуулсанаар хурал эхлэв.

ХЭЛЭЛЦЛЭХ АСУУДАЛ

**1 дэх асуудал:** Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэсэн 2016 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг батлах.

**1 дэх асуудал хэлэлцсэн нь:** Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэсэн 2016 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг батлах.

**1.Танилцуулсан нь:** Хурлын дарга С.Халиунаа: Жинст Увс ХК нь 2016 онд үйл ажиллагаа явуулаагүй ба санхүүгийн тайланд БДО Аудит ХХК-иар аудитын шалгалт хийлгэж, санхүүгийн тайлан аудитлагдсан талаар талаар танилцуулав.

**Хувьцаа эзэмшигч:** Д.Мөнхтөр: Санхүүгийн тайланд ашиг, алдагдал 122,000 төгрөг байна энэ талаар тайлбар авахыг хүсч байна.

**Ерөнхий нягтлан бодогч Б.Оюунсувд:** Хөрөнгө Оруулагч Үндэстэн ХК-тай нэгдэх, мөн, хувьцаа эзэмшигчдийн хурал зохион байгуулахтай холбогдуулан ҮЦТХТ-өөс тархалтын мэдээ авах зэрэг бичиг баримтын зардал гарсан. Мөн Монголын Хөрөнгийн Биржид бүртгэлтэй компаниудынбүртгэлийн төлбөр, ҮЦТХТ-ийн бүртгэлийн төлбөр зэргийг компани мөнгөгүй тул Ард Санхүүгийн Нэгдэл ХК-аас төлсөн

**Дараах зүйлийг баталсан тухай шийдвэр:**

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх хэсэг, 2017 оны 4 сарын 21-ний өдрийн Тооллогын комиссын 01/17 тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэсэн Жинст Увс ХК-ийн 2016 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг баталсугай.

Энэ асуудлаар санал хураасан дүн:

| №  | Хувьцаа эзэмшигчийн нэр  | Санал   |           |            |
|----|--------------------------|---------|-----------|------------|
|    |                          | Дэмжсэн | Дэмжээгүй | Түдгэлзсэн |
| 1. | Ард Санхүүгийн Нэгдэл ХК | +       |           |            |
| 2. | Д.Мөнхтөр                | +       |           |            |

**2 дахь асуудал:** Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгож, томиох тухай.

**2 дахь асуудал хэлэлцсэн нь:** Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгож, томиох тухай.

**2.Танилцуулсан нь:** Хурлын дарга С.Халиунаа: компанийн дүрэмд Төлөөлөн Удирдах Зөвлөлийн бүрэн эрхийн хугацааг тодорхой тусгаагүй тул Компанийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2-т заасны дагуу Төлөөлөн Удирдах Зөвлөлийн бүрэн эрх энэхүү хувьцаа эзэмшигчдийн хурлаар дуусгавар болж байгаа тул хуулийн Төлөөлөн Удирдах

Зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгож, томиохоор хэлэлцэх асуудалд оруулсан. Мөн хуульд заасанчлан Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг улируулан сонгож болох бөгөөд Жинст Увс ХК-ийн тухайд өнөөдрийн хурлаар өмнөх ТУЗ-ийн гишүүд нэр дэвшиж байгаагаас гадна ердийн гишүүнд Г.Билгүүн, хараат бус гишүүнд М.Галиндэв нар нэр дэвшиж байгаа талаар талаар танилцуулав.

**Дараах зүйлийг баталсан тухай шийдвэр:**

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь хэсэг, 2017 оны 04 сарын 21-ний өдрийн 17/01 тоот Хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэл болон Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

**1. “Жинст Увс” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүдээр**

1. Чулуун овогтой овогтой Ганхуяг
2. Чулуун овогтой Ганзориг
3. Барамсай овогтой Ганбат
4. Мөнх-Очир овогтой Сэргэлэн
5. Арьяасүрэн овогтой Батболд
6. Пүрэвжаргал овогтой Батбаяр

**2. “Жинст Увс” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн Хараат бус гишүүдээр**

1. Дэмбэрэл овогтой Мөнхтөр
2. Хишигдалай овогтой Далайбаяр
3. Өнөрбаян овогтой Ашхүү нарыг тус тус томилсугай.

Энэ асуудлаар санал хураасан дүн:

| №  | Хувьцаа эзэмшигчийн нэр  | Санал   |           |            |
|----|--------------------------|---------|-----------|------------|
|    |                          | Дэмжсэн | Дэмжээгүй | Түдгэлзсэн |
| 1. | Ард Санхүүгийн Нэгдэл ХК | +       |           |            |
| 2. | Д.Мөнхтөр                | +       |           |            |

Хурал 16:20 цагт өндөрлөв.

Хурлын протокол хөтөлсөн:

ХУРЛЫН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Ж.АЛТАНГҮНИЙ

Танилцсан:

ХУРЛЫН ДАРГА



С.ХАЛИУНАА